МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 13 өдөр Дугаар А/300 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын үзлэгийг Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн салбарын өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б. Батбилгүүн-(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

Гишүүд: А.Цэнд-Аюуш-(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч)

Н.Ичинноров-(Эрүүл мэндийн газрын орчны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:
Б.Нямдаваа-(Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Улсын үзлэгийг 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 13-ны өдрийн дотор зохион байгуулж, тайланг аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд 2022 оны 10 дугаар сарын 28-ны дотор хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Батбилгүүн)-д үүрэг болгосугай.

3. Үзлэг шалгалтын замын зардал 2,808,588 (Хоёр сая найман зуун найман мянга таван зуун наян найм) төгрөгийг аймгийн Засаг дарга ерөнхий дансны "Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамтын ажиллагаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны үйл ажиллагааны дэмжлэг" зардлаас

зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН